



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА



2018 он

АГУУЛГА

1. Судалгааны зорилго
2. Аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбаарн үүсэл хөгжил
3. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах бизнесийн орчин
4. Аймгийн аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын өнөөгийн байдал
 - Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт, аймгийн ДНБ-д нэмэгдэл өртгийн эзлэх хувь
 - Аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын тоо, аймгийн нийт ажиллагчдад эзлэх хувь
 - Аж үйлдвэрийн гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
 - Барилгын салбарын нийт үйлдвэрлэлт, аймгийн ДНБ-д нэмэгдэл өртгийн эзлэх хувь
 - Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл
 - Худалдааны салбарын нийт борлуулалт, нэмэгдэл өртгийн хэмжээ, аймгийн ДНБ-нд нэмэгдэл өртгийн эзлэх хувь
 - Худалдааны салбарын ажиллагчдын тоо, хөдөлмөрийн бүтээмж
 - Нийтийн хоолны салбарын нийт бараа гүйлгээ
 - Үйлчилгээний бусад салбарын үзүүлэлт
 - Тээврийн салбарын үзүүлэлтүүд
 - Холбооны салбарын үзүүлэлтүүд
5. Дүгнэлт, санал

1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Аймгийн эдийн засаг, дэд бүтцийн үндсэн үзүүлэлтээр нэгдсэн танилцуулга бэлтгэн, эдгээр үзүүлтүүдэд гарсан өөрчлөлт, цаашдын чиг хандлагыг тодорхойлон, орон нутгийн удирдлага, бодлого хариуцсан ажилтнуудыг мэдээллээр хангахад чиглэнэ.

2. АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ



Аж үйлдвэр

Аймгийн аж үйлдвэрийн салбар нь анх 1976 онд уул уурхайн олборлолт, мод боловсруулах чиглэлээр үүсчээ. 1980 оноос ноос, ноосон нэхмэл, оёдол, хэвлэл, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, цахилгаан дулаан эрчим хүч үйлдвэрлэл, төмөрлөгийн үйлдвэр, барилгын материал үйлдвэрлэл, нефть боловсруулах үйлдвэрлэл, шахмал түлш, цаас, эмийн ургамал, гоо сайхны бүтээгдэхүүн боловсруулах, шингэн шил химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, цахилгаан утас, ацетелин вакум буюу хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл, арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хоёрдогч түүхий эд боловсруулах, түлш, хөөсөнцөр хавтан үйлдвэрлэл, шилэн хийц, цахилгаан гэрэл чийдэн, түүхий резин, баяжмалын даавуун шүүлтүүр үйлдвэрлэл гэх мэт жил бүр хөгжсөөр 2017 оноос плитаны цавуу, хар замаск, бэлтгэлийн хувцас үйлдвэрлэл бий болж өргөжсөөр байна.



Барилгын салбар

Орхон аймгийн барилгын байгууллагуудын үүсэл хөгжил нь Зэс-молибдений уул уурхайн баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр, Эрдэнэт хотыг барьж байгуулсантай холбоотой.

Уул уурхайн баяжуулах “Эрдэнэт” комбинат, Эрдэнэт хотын барилга байгууламжийг барих ажлын ерөнхий гүйцэтгэлээр ЗСБНХУ-ын хүнд үйлдвэрийн барилгын яам өөрийн яамны харъяа “Главзарубежстрой” байгууллагад “Мед молибденстрой” барилгын удирдах газрыг 1974 онд байгуулан Эрдэнэтэд төлөврүүлжээ. Ерөнхий гүйцэтгэгч “Медмолибденстрой” удирдах газрын харъяанд гурван удирдах газар болон бусад туслан гүйцэтгэгч байгууллагууд байгуулагдан барилга байгууламжийг барьж хөгжлийг эхэлжээ.



Худалдааны салбар

Эрдэнэт хотын хөгжлийн эхэн үед 11 дэлгүүр, 3 зоогийн газар, нийт 14 худалдааны цэг ажиллаж байсан бол худалдаа үйлчилгээний хөгжил, зах зээлийн хүрээ өдрөөс өдөрт нэмэгдэн тэлсээр эдүгээ 742 худалдааны нэгж, салбар, 232 ахуйн үйлчилгээний цэг үйл ажиллагаа явуулж байна.



Тээвэр, холбооны салбар

Өргөн уудам нутагтай, хүн ам харьцангуй сийрэг суурьшдаг манай орны хувьд тээвэр эдийн засгийн амьдралд чухал ач холбогдолтой салбарын нэг билээ. Аймгийн тээврийн салбар 1974 онд газ-53, 2-автобус, 2-автомашинтай нийт 5 ажилчинтай авто

баазын сууриар үүсчээ. Зах зээлийн харилцааны дагуу тэлж хөгжисөөр эдүгээ хотын дотор 12 маршрут, 28 таксийн зогсоолын чиглэлээр 56 автобус, 34 микро автобус, 522 суудлын автомашинаар иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж байна.

Орхон аймгийн холбооны салбар нь 1970 оноос Эрдэнэтийн овооны зэс молибденыг олборлох үйлдвэрийг барьж ажил эхэлсэнээр Эрдэнэт хот, түүнийг дагаад холбоо харилцаа үүсч хөгжсөн байна. Геологийн тосгоны 7-р байранд 30-аад ажилтантай, хот хоорондын холбоо, хотын холбоо, шуудан тасагтайгаар зохион байгуулагдаж, найрамдлын шинэ залуу хотын олон мянган бүтээн байгуулагчдад үйлчилж эхэлсэн байна. Энэ үед АТС 50/200 маркын автомат телефон станц, УБ-Дархан хоттой харилцах ПВ-12-2, СВК-4, Булган аймагтай харилцах В-3-3 олон сувгийн агаарын шугамын нягтруулгын төхөөрөмжийг тус тус суурилуулан, ТУ-100 өсгөгчөөр радио өргөн нэвтрүүлгийн программыг дамжуулж байжээ.

Аймагт мэдээлэл харилцаа холбооны үйлчилгээг үүрэн телефоны үйлчилгээ эрхлэгч операторууд, интернет үйлчилгээ эрхэлж буй цэг нэгж, хэвлэл мэдээлэл гээд төрийн болон бизнесийн 50 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

3. АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ БИЗНЕСИЙН ОРЧИН

Орхон аймаг 84.4 мян.га нутаг дэвсгэртэй, далайн түвшнээс 1200 метрт өргөгдсөн, Улаанбаатар хотоос 420 км, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул аймгаас 60-280 км-ийн зайтай оршдог.

Аймгийн хэмжээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар 101652 хүн ам, 28704 өрх бүртгэгдсэн. Аймгийн төвд нийт өрх хүн амын 95.2 хувь нь оршин суудаг. Хангайн бүсийн хөгжлийн тулгуур төв болсон Эрдэнэт хот дэд бүтэц харьцангуй хөгжсөн нийслэл Улаанбаатар хот, Дархан-Уул аймаг, Сэлэнгэ аймагтай засмал зам болон төмөр замаар холбогдсон, Эрдэнэт-Булган-Хөвсгөлийн чиглэлд засмал замтай болсон нь зах зээл өргөжин хөгжих нөхцөл болж байна.

БНХАУ-ын Бугат, Ордос, Эрээн хотуудтай, ОХУ-ын Улан-Үдэ, Усолье Сибирск, Булгар улсын Бургас, ХБНГУ-ын Миттавайда хот, Швед улсын Сигтуна, АНУ-ын Аляск мужийн Файрбанк хот, Чек улсын Плзен, БНУУ-ын Сэкэшфэхервар хотуудтай найрамдал хамтын ажиллагаатай ажилладаг, монголын арилжааны бүх банкны салбартай, шатахуун нийлүүлэлтийн 6 компанийн 19 түгээх станц, авто машины газ борлуулалтын 5 түгээх цэг үйл ажиллагаа эрхэлдэг.

Харилцаа холбооны хувьд автомат станц, шилэн кабель, Мобиком, Скайтел, Юнител, G мобайлын үүрэн телефон холбоотой, насанд хүрсэн хүн бүр үүрэн телефон хэрэглэгч байна.

Эрчим хүчний өндөр хүчдэлийн цахилгаанаар хангагдсан ба Эрдэнэт Булганы ЦТС нь Булган аймагт цахилгаан түгээн борлуулдаг.

Гадаад худалдааны хувьд төмөр замаар урд болон хойд хөрштэй шууд харилцдаг.

4. АЙМГИЙН АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт, аймгийн ДНБ-д нэмэгдэл өртгийн эзлэх хувь:

Манай аймагт аж үйлдвэрийн 3 салбарын 19 дэд салбарын нийт 174 цэг нэгж үйлдвэрлэл эрхлэн зах зээлд нийлүүлж байгаас уул уурхайн олборлох аж үйлдвэрийн салбарт 4, боловсруулах салбарт 168, цахилгаан дулааны эрчим хүчний салбарт 2 нэгж үйлдвэрлэл эрхлэн 160 гаруй нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

2017 онд 2.1 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, 2.2 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх оноос үйлдвэрлэлт 50.2 хувиар, борлуулалт 48.9 хувиар өссөн байна.

Нийт бүтээгдэхүүний 92.5 хувь уул уурхайн олборлох салбарт, 5.8 хувь боловсруулах салбарт, 1.7 хувь цахилгаан эрчим хүч, дулаан үйлдвэрлэлийн салбарт бий болжээ.

Зураг 1. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн салбарын бүтэц, 2017 он



Хүснэгт 1. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт, салбараар /сая.төг/

Салбарын ангилал	2016		2017		2017/2016=%	
	Нийт бүтээгдэхүүн, оны үнээр	Аж үйлдвэрийн борлуулалт	Нийт бүтээгдэхүүн, оны үнээр	Аж үйлдвэрийн борлуулалт	Нийт бүтээгдэхүүн, оны үнээр	Борлуулалт
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭР	1240145.1	1239667.2	1927012.2	1891375.1	155.4	152.6
Металлын хүдэр олборлолт	1239971.4	1239479.5	1926895.6	1891239.4	155.4	152.6
Бусад ашигт малтмал олборлолт	173.7	187.7	116.5	135.7	67.1	72.3
БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭР	114735.7	227277.4	121260.1	306639.7	105.7	134.9
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	13115.1	13302.8	14439.1	17263.0	110.1	129.8
- <i>Мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл</i>	2075.6	1951.8	2862.0	3289.1	137.9	168.5
- <i>Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл</i>	1113.8	1230.7	973.8	1106.1	87.4	89.9
- <i>Үр тарианы гурил, малын тэжээл</i>	7204.2	7100.3	7036.4	8902.6	97.7	125.4
- <i>Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл</i>	2356.2	2649.8	3414.6	3742.5	144.9	141.2
- <i>Архи, дарс, ундаа үйлдвэрлэл</i>	365.3	370.2	152.2	222.8	41.7	60.2
Ноосон нэхмэлийн үйлдвэрлэл	26918.3	32106.3	34830.6	37605.7	129.4	117.1
Оёдлын үйлдвэрлэл	2265.6	3300.0	5472.4	5418.5	2.4 ²	164.2
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	29.0	10.2	30.4	20.4	104.8	199.9
Мод модон эдлэл үйлдвэрлэл	74.8	24.3	11.7	59.1	15.7	2.4 ²
Тавилга үйлдвэрлэл	74.4	106.3	81.9	161.2	110.1	151.6
Хэвлэх үйлдвэрлэл	591.7	722.0	668.8	770.8	113.0	106.8
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	34.6	45.0	72.6	84.1	2.1 ²	186.8
Хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1392.7	1548.8	1090.1	1496.0	78.3	96.6
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	5054.0	3358.3	4303.0	3156.5	85.1	94.0
Төмрийн үйлдвэрлэл	61812.4	168985.3	58146.4	237263.2	94.1	140.4
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	2764.5	2930.9	1559.8	2709.9	56.4	92.5
Цахилгаан машин, хэрэгсэл үйлдвэрлэл	433.7	619.9	422.4	438.3	97.4	70.7
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1.7	10.2	14.0	8.3	8.3 ²	80.9
Хоёрдогч түүхий эд бэлтгэл	173.2	207.1	116.7	184.8	67.4	89.2
ЦАХИЛГААН, ХИЙ, ДУЛААН ҮЙЛДВЭРЛЭЛ	32083.8	32084.3	34642.0	34392.6	108.0	107.2
НИЙТ ДҮН	1386964.6	1499028.9	2082914.2	2232407.4	150.2	148.9

Зураг 2. Нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, тэрбум төгрөгөөр



Аж үйлдвэрийн салбарын дүнгээр 2017 онд 1.6 триллион төгрөгийн нэмэгдэл өртөг үйлдвэрлэгдсэн нь аймгийн ДНБ-ны 90.0 орчим хувийг бүрдүүлж байна. Дэд салбарын хувьд 92.5 хувь нь уул уурхайн олборлох салбарт, 5.8 хувь нь боловсруулах үйлдвэрийн салбарт, 1.7 хувь нь цахилгаан, дулааны эрчим хүчний салбарт тус тус бий болжээ.

Аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын тоо, аймгийн нийт ажиллагчдад эзлэх хувь:

1976 онд 135 ажиллагсад ажиллаж байсан бол жилд дунджаар 2.4 хувиар нэмэгдсээр 2017 онд 8634 болж аймгийн нийт ажиллагсдын 33.3 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2. Аймгийн аж үйлдвэрийн үндсэн үзүүлэлтүүд

Он	Үйлдвэрлэлт, оны үнээр, сая.төг	Борлуулалт, онь үнээр, сая.төг	Ажиллагсдын тоо	Хөдөлмөрийн бүтээмж, сая.төг	Нэг өдрийн үйлдвэрлэлт, мян.төг	Нэг хүнд ногдох аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, мян.төг
2012	1296781.6	1288387.0	8986	144.3	3602171.1	14344.9
2013	1271736.3	1268782.9	9254	137.4	3532600.8	13959.8
2014	1389976.1	1444643.1	9118	152.4	3808153.6	14945.9
2015	1243437.1	1303592.0	9004	138.1	3406677.0	12591.8
2016	1386964.6	1499028.9	8579	161.7	3799903.0	13611.4
2017	2082914.2	2232416.0	8634	241.2	5706614.4	20100.5

2017 оны байдлаар нэг ажиллагч 241.2 сая төгрөгийн, нэг өдөрт 5706.6 сая төгрөгийн бүтээгдэхүүн бий болгож байна.

Нэг хүнд ногдох аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ 2017 онд 20.1 сая төгрөг болж өмнөх оноос 47.7 хувиар өссөн байна.

Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт:

Хүснэгт 3. Гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, биет хэмжээ

№	Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2016	2017	$\frac{2017}{2016}$ %
1	Зэсийн баяжмал металл	мян.тн	598.5	595.1	99.4
2	Молибдений баяжмал	тн	5174.0	5759.3	111.3
3	Катодын зэс, 99%	тн	15010.0	14644.0	97.6
4	Цахилгаан эрчим хүч	сая.квт.цаг	118.8	130.7	110.0
5	Дулааны эрчим хүч	мян.Гкал	899.7	916.2	101.8
6	Тараг	мян.л	334.5	281.2	84.1
7	Зайрмаг	мян.ш	353.9	829.9	234.5
8	Гурил I зэрэг	тн	6437.0	6192.1	96.2
9	Гурил II зэрэг	тн	623.6	632.1	101.4
10	Хивэг	тн	2712.0	2448.8	90.3
11	Нарийн боов	тн	657.7	798.1	121.3
12	Талх	тн	167.6	265.8	158.6
13	Гоймон	тн	14.6	16.6	113.7
14	Хивс	мян.м2	397.2	443.5	111.7
15	Эсгий	мян.м	32.0	45.6	142.5
16	Вакуум хаалга, цонх	м2	5371.8	10718.7	199.5
17	Шавардлагын зуурмаг	м3	188.9	220.4	2.1 ²
18	Металл бэлдэц	тн	492.8	205.2	41.6
19	Ган төмөр хийц/ганбөмбөлөг/	тн	1056.0	2433.5	230.4

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл жил бүр нэмэгдсээр өнөөгийн байдлаар 160 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн гаргаж байна.

Зэс, молибдений баяжмалаас гадна катодын зэс, хивс, эсгий, эсгий шаахай, оёмол хөнжил, нэхмэл хөнжил, ноос ноолууран нөмрөг, ороолт, шаль, сүлжмэл бүтээгдэхүүн, малын мах, хөх тарианы гурил зэрэг бүтээгдэхүүнийг экспортод гаргаж бусад бүтээгдэхүүнийг өөрийн аймагт болон бусад орон нутгийн зах зээлд нийлүүлж байна.

Гурил, арвайн гурил, талх, нарийн боов, хиам, зайрмаг, цэвэр ус зэрэг хүнсний бүтээгдэхүүнийг хөрш зэргэлдээ Булган аймгийн Баян-Агт, Бугат, Сайхан, Ингэт, Хангал, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумдын зах зээлд гаргаж хүн амын хэрэгцээг хангаж байна.

Зураг 3. Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүний хөгжлийн түүх

2017	Плитаны цавуу, хар замаск, бэлтгэлийн хувцас
2016	Түүхий резин, баяжмалын уут
2015	Лед чийдэн, туузан гэрэл
2014	Чипс
2013	Дизелийн түлш, арвайн гурил, цахилгаан уртасгагч залгуур, хөөсөнцөр хавтан
2012	Бүс, хүүхдийн савхин гутал, жааз
2006	Нүүрс, алт, мөнгө, хөшиг
2005	Цувимал зэс, шахмал түлш, улаан тоосго, замын хавтан, ноолууран сүлжмэл бүтээгдэхүүн, ариун цэврийн цаас
2002	Цутгамал бүтээгдэхүүн, бензин, цэвэр ус
2001	Малын мах
2000	Үрлэн чихэр
1997	Катодын зэс
1996	Гахайн мах
1995	Хиам
1993	Гурил
1985	Цахилгаан дулаан
1984 он хүртэл	Зүсмэл, зэсийн баяжмал, молибдений баяжмал, хивс, Талх, нарийн боов, архи, пиво, ундаа



Их барилга

Барилгын салбарын нийт үйлдвэрлэлт, нэмэгдэл өртгийн хэмжээ, аймгийн ДНБ-д нэмэгдэл өртгийн эзлэх хувь:

Хүснэгт 4. Нэмэгдэл өртөг, сая.төг

	Нийт гаргалт		Завсрын хэрэглээ		Нэмэгдэл өртөг	
	2016	2017	2016	2017	2016	2017
Их барилга	79410.2	68213.4	49089.9	42168.2	30320.3	26045.2

Өмнөх онтой харьцуулахад барилгын салбарын нэмэгдэл өртөг 14.1 хувиар бага байна.


Эдүгээ 100 гаруй барилгын байгууллага жилд дунджаар 60.0 орчим тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг хийж гүйцэтгэж байна.

Хүснэгт 5. Их барилгын салбарын зарим үзүүлэлтүүд

		Барилгын байгууллагын тоо	Ажиллагсадын тоо	Гүйцэтгэсэн БУА, их засвар, сая.төг	Үүнээс: орон нутгийн төсвийн хөрөнгөөр, сая.төг	Барилгын нэг ажиллагчийн бүтээмж, мян.төг
2017		113	1396	67634.2	19297.7	48.0
2018		123	1540	58117.6	23648.1	38.0
Өсөлт, бууралт	тоо	10	144	-9516.6	4350.4	-10.0
	хувь	108.8	110.3	85.9	122.5	79.2

2017 онд 58.1 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсний 40.7 хувь нь буюу 23.6 тэрбум төгрөгийн ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэжээ.

Зураг 4. Гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил



Нэг ажиллагчийн бүтээмж 38.0 мянган төгрөг болсон нь өмнөх оноос 20.8 хувиар буурчээ.

Хүснэгт 6. Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ, сая төгрөг

	2016	2017	2017/2016	
			хувь	тоо
Барилга угсралт их засварын ажлын дүн	67634.2	58117.6	85.9	-9516.6
Үүнээс их засварын ажил	16511.7	21916.6	132.7	5404.9
Орон нутгийн төсвөөр хийгдсэн БУА, их засвар	19297.7	23648.1	122.5	4350.4
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн БУА, их засвар	3403.4	3975.9	116.8	572.5

Гүйцэтгэсэн ажлын 37.7 хувь буюу 21.9 тэрбум төгрөг нь их засварын ажил байна. Өмнөх оноос гүйцэтгэсэн нийт ажлын хэмжээ 14.1 хувиар буурч, харин их засварын ажил 32.7 хувиар өсчээ. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 23.6 тэрбум төгрөгийн, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 4.0 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийж гүйцэтгэснээр өмнөх оноос орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажил 22.5 хувиар, улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажил 16.8 хувиар өсчээ.

Худалдааны салбар**Худалдааны салбарын нийт борлуулалт, нэмэгдэл өртгийн хэмжээ, аймгийн ДНБ-нд нэмэгдэл өртгийн эзлэх хувь:**

Аймгийн худалдаа нийтийн хоолны 742 цэг салбар 114.1 тэрбум төгрөгийн бараа гүйлгээ хийж, бараа гүйлгээний нийт хэмжээ өмнөх оноос 9.1 хувиар өссөн байна. Өмнөх оноос хүнсний дэлгүүрийн орлого 0.3 хувиар, барааны дэлгүүрийн орлого 3.7 хувиар, авто засварын газрын орлого 18.2 хувиар, шатахуун борлуулалтын орлого 19.2 хувиар, зоогийн газрын орлого 21.8 хувиар, барилгын материалын дэлгүүрийн орлого 66.7 хувиар, авто сэлбэгийн дэлгүүрийн орлого 68.8 хувиар нэмэгдэж, эм борлуулалтын орлого 9.1 хувиар, ТҮЦ-ний орлого 14.5 хувиар, контейнерийн орлого 73.4 хувиар, буурчээ.

Хүснэгт 7. Худалдаа, нийтийн хоолны салбарын гүйлгээ, сая.төг


Үзүүлэлт	2016		2017		2017 2016=%
	цэгийн тоо	бараа гүйлгээ	цэгийн тоо	бараа гүйлгээ	
Барааны дэлгүүр	75	9235.1	75	9576.8	103.7
Хүнсний дэлгүүр	373	41679.9	385	41821.9	100.3
Үүнээс: согтууруулах ундааны гүйлгээ	284	12325.4	296	12829.9	104.1
Авто сэлбэгийн дэлгүүр	17	780.1	18	1316.8	168.8
Барилгын материалын дэлгүүр	18	1312.0	19	2187.3	166.7
Зоогийн газар	138	16037.8	139	19541.9	121.8
Үүнээс: Ресторан бар	84	5434.4	86	7169.3	131.9
ТҮЦ	9	20.0	6	17.1	85.5
Контейнер	5	1140.0	6	303.3	26.6
Авто засварын газар	31	260.4	29	307.9	118.2
Шатахууны борлуулалт	7	28333.4	12	33764.2	119.2
Үүнээс: Газын борлуулалт	1	1706.5	5	4595.8	2.7 ²
Эм борлуулалт	47	5818.5	53	5291.1	90.9
ДҮН	720	104617.2	742	114128.3	109.1

Нийт бараа гүйлгээний 36.6 хувийг хүнсний дэлгүүр, 29.6 хувийг шатахуун борлуулалт, 17.1 хувийг зоогийн газар, 8.4 хувийг барааны дэлгүүр, 4.6 хувийг эм

борлуулалтын орлого, 1.9 хувийг барилгын материалын дэлгүүрийн орлого, 1.2 хувийг авто сэлбэгийн дэлгүүрийн орлого, 0.3 хувийг контейнерийн орлого, 0.3 хувийг авто засварын газрын орлого эзэлж байна.

2017 оны байдлаар 1000 хүнд 1122.7 сая төгрөгийн бараа гүйлгээ ноогдож өмнөх оноос 63.3 сая төгрөгөөр өссөн байна.

Зураг 5. Бараа гүйлгээний бүтэц



Аймгийн нэмэгдэл өртгийн 4.6 хувь нь худалдааны салбарт бий болж, энэ нь өмнөх оноос 0.1 пунктээр буурсан байна.

Хүснэгт 8. Худалдааны салбарын нэмэгдэл өртөг

Үзүүлэлт	Дүн (сая төгрөг)		Аймгийн НБ-нд эзлэх хувь	
	2016	2017	2016	2017
Нэмэгдэл өртөг	57191.4	62395.8	4.7	4.6


Худалдааны салбарын ажиллагчдын тоо, аймгийн нийт ажиллагчдад эзлэх хувь, дэд салбараар

Хүснэгт 9. Худалдаа салбарын ажиллагсад

Үзүүлэлт	Тоо		Аймгийн нийт ажиллагсдад эзлэх хувь	
	2016	2017	2016	2017
Худалдааны салбарт ажиллагсад	5081	5788	15.3	18.0


Салбарын нэг ажилтаны бүтээмж 2010-2013 онд жилд дундажаар 42.4 хувиар өсч байсан бол 2014-2015 онд буурч 2016 онд 20.6 сая төгрөг, 2017 онд 19.7 сая.төгрөг болж өмнөх оноос 4.4 хувиар буурсан байна.

Зураг 6. Худалдааны салбарын бүтээмж



Нийтийн хоолны салбарын нийт бараа гүйлгээ

Зураг 7. Салбарын бараа гүйлгээний өсөлтийн диаграмм, сая.төг



Үйлчилгээний бусад салбарын үзүүлэлтүүд

Нийтийн аж ахуйн үйлчилгээний орлого 16.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 2.0 хувиар өссөн байна.

Нийт орлогын 87.6 хувийг орон сууцны орлого бүрдүүлж байгаа нь дийлэнхи хувийг эзэлж байна.

Хүснэгт 10. Нийтийн аж ахуйн үйлчилгээний орлого, сая.төгрөгөөр

	2016	2017	2017/2016=%	Дүнд эзлэх хувь
Орон сууцны орлого	6869.1	7415.6	108.0	46.2
Аж ахуйн нэгж, албан газрын орлого	6510.3	6643.9	102.1	41.4
Зочид буудал	1291.2	1048.9	81.2	6.5
Зөөврийн цэвэр ус борлуулалт	383.7	242.7	63.3	1.5
Халуун ус	58.6	81.0	138.2	0.5
Саун	50.1	35.1	70.1	0.2
Засвар үйлчилгээний орлого	86.2	43.4	50.3	0.3
Хог тээвэрлэлт	481.6	540.4	112.2	3.4
Иргэдийн үйлчилгээ	0.5	0.05	10.0	0.0
Бүгд	15731.3	16051.1	102.0	100.0

Хүснэгт 11. Ахуйн үйлчилгээний орлого, сая.төгрөгөөр

	2016		2017		2017/2016=%	Дүнд эзлэх хувь, 2017
	Цэгийн тоо	Орлого	Цэгийн тоо	Орлого		
Үсчин	53	560.6	49	545.7	97.3	32.8
Зурагчин	6	47.4	5	58.9	124.3	3.5
Цаг засвар	1	3.3	1	3.7	112.1	0.2
Хими цэвэрлэгээ	2	46.8	2	38.5	82.3	2.3
Гутал засвар	13	60.3	14	64.4	106.8	3.9
Телевизор засвар	2	10.6	2	8.1	76.4	0.5
Ломбард	149	839.2	138	837.6	99.8	50.3
Прокат ба тоглоомын цэг	28	156.1	21	108.4	69.4	6.5
Бүгд	254	1724.3	232	1665.3	96.6	100.0



Тээвэр, харилцаа холбоо


2017 онд тээврийн салбарт 7.4 тэрбум төгрөгийн, холбооны салбарт 353.5 сая төгрөгийн нэмэгдэл өртөг бий болсон нь 2016 оныхоос 16.3-21.3 хувиар буурсан байна.

Тээвэр, холбооны салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн аймгийн нийт нэмэгдэл өртгийн 0.3 хувь, улсын тээвэр, холбооны салбарын нийт нэмэгдэл өртгийн 0.02 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 12. Тээврийн салбарын үзүүлэлт


	Х/Н	2016	2017	2017/2016=%
Тээсэн ачаа	мян.тн	168.9	153.7	91.0
Ачаа эргэлт	м/т/км	50419.9	51154.1	101.5
Тээсэн зорчигч	мян/хүн	5287	4908	92.8
Зорчигч эргэлт	м/хүн/км	101568.5	101242.1	99.7
Тээврийн орлого	сая.төг	22705.3	17881.8	78.8
Тээврийн үйлчилгээнд гарсан:				
Автобус	тоо	56	70	125.0
Микро автобус	тоо	34	27	79.4
Такси	тоо	522	503	96.4
Тээврийн үйлчилгээ эрхэлж буй:				
ААН	тоо	10	10	100.0
Ажиллагсдын тоо	тоо	838	878	104.8

Зураг 8. Тээврийн салбарын үзүүлэлт




2017 онд аймгийн дүнгээр 10 аж ахуйн нэгжийн, 878 иргэн, 70 автобус, 27 микроавтобус, 503 такси тээврийн үйлчилгээ явуулж 153.7 мян.тн ачаа тээвэрлэн, 51.2 сая.тн/км-ийн ачаа эргэлт, 4.9 сая зорчигч тээвэрлэн, 101.2 сая.хүн/км-ийн зорчигч эргэлт гүйцэтгэж 17.9 тэрбум төгрөгийн орлоготой ажиллажээ. Өмнөх оноос тээврийн орлого 21.2 хувь, зорчигч эргэлт 0.3 хувиар буурч, ачаа эргэлт 1.5 хувиар өсчээ.

Зураг 9. Тээсэн ачаа, мян.тн



Зураг 10. Зорчигч эргэлт, мян.хүн.км



Холбооны орлого 2016 онд 7.7 тэрбум төгрөг байсан бол 2017 онд 6.4 тэрбум төгрөгт хүрч, 16.3 хувиар буюу 1.2 тэрбум төгрөгөөр буурчээ. Телевизорын тоо өмнөх оноос 1.7 хувиар буюу 284 цэгээр өсч, КТВ-ийн цэгийн тоо 7.6 хувиар буурч, радио цэгийн тоо өмнөх оны түвшинд байна.

Хүснэгт 13. Холбоо үйлчилгээний орлого /сая.төг/, радио цэгийн тоо

Үзүүлэлтүүд	2016	2017	2017/2016=%
Нийт орлого	7678.9	6425.2	83.7
Үүнээс: Хүн амын орлого	7017.3	5890.3	83.9
Телефон цэг, тоо	4532	4074	89.9
Үүнээс: Айл өрх	1224	879	71.8
Радио цэг	3298	3298	100.0
Үүнээс: Айл өрх	2426	2426	100.0
Телевизор, тоо	16396	16680	101.7
Үүрэн телефон хэрэглэгчид	215479	240694	111.7
Үүнээс карт эзэмшигчид	204375	225452	110.3
КТВ-ийн цэгийн тоо	15388	14223	92.4
Таксоны тоо	1	1	100.0
Интернет: Цэгийн тоо	9	9	100.0
Үйлчлүүлэгчдийн тоо	38282	26647	69.6
Байнгын хэрэглэгч	6455	6624	102.6
Нийт орлогоос: Интернет	51.2	23.3	45.5
КАТВ, TV	1590.6	1625.5	102.2
Үүрэн телефон	4980.6	3896.1	78.2
Монголын цахилгаан холбоо	1062.5	441.0	41.5
Төмөр замын холбоо	7.2	14.3	198.6
Мэдээлэл холбооны сүлжээ	399.2	425.0	106.5

Аймгийн хэмжээнд үүрэн телефон хэрэглэгчийн тоо 240.7 мянга болж өмнөх оноос 11.7 хувиар буюу 25.2 мянган хэрэглэгчээр нэмэгдэж, 6-аас дээш насны хүн ам тутамд 3 орчим ширхэг гар утас оногдож байна. Холбооны салбарын нийт орлогын 91.7 хувийг хүн амаас орсон орлого эзэлж буй бөгөөд бүх орлогын 60.6 хувь нь үүрэн телефоны орлого байна. 2017 онд интернет цэгүүд 26.6 мянган хүнд үйлчилж 23.3 сая төгрөгийн орлого олсон нь өмнөх оноос 54.5 хувиар буурсан байна. Интернет хэрэглэгчидээс байнгын 6.6 мянган хэрэглэгч байгаа нь өмнөх оноос 2.6 хувиар их байна.

5. ДҮГНЭЛТ, САНАЛ

Манай аймагт аж үйлдвэрийн 19 дэд салбарын 174 аж ахуйн нэгж, иргэд үйлдвэрлэл эрхлэн 160 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн гаргаж байна.

Аймгийн хувьд голлох салбар уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар хэдий ч боловсруулах салбар нийт үйлдвэрлэлтийн 5.8 хувийг эзэлж, энэ нь цаашид хөгжүүлэх боломжтой салбар хэвээр байна. 2017 онд боловсруулах салбарын нийт үйлдвэрлэлтийн

48.0 хувийг төмрийн үйлдвэрлэл, 28.7 хувийг нэхмэлийн үйлдвэрлэл, 11.9 хувийг хүнсний бүтээгдэхүүн, ундаа, ус үйлдвэрлэл, 3.5 хувийг төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэлийн үйлдвэрлэл, 4.5 хувийг оёдолын үйлдвэрлэл, үлдсэн 3.4 хувийг бусад боловсруулах үйлдвэрлэл эзэлж байна.

2017 онд аймгийн аж үйлдвэрийн салбарт үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн улсын хэмжээний аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 14.7 хувь, Бүсийн нийт бүтээгдэхүүний 97.3 хувийг бүрдүүлж байна.

Бүсийн аймгуудтай харьцуулахад харьцангуй өндөр байгаа нь аж үйлдвэржсэн хот болохыг илтгэж байна.

Өмнөх оноос улсад эзлэх хувь 1.7 пунктээр, хангайн бүсэд эзлэх хувь 0.5 пунктээр өссөн байна.

Аж үйлдвэрийн үйлдвэрлэлтээр улсад Улаанбаатар хотын дараа 2-рт жагсаж байна.

Сүүлийн жилүүдэд барилга угсралтын ажил нилээд явагдаж томоохон орон сууцнууд баригдаж байсан боловч 2017 оны хувьд жилүүдэд барилга угсралтын ажил бага, их засварын ажил их хийгдсэнээс барилгын салбарын орлого буурсан байна. Улсын дүнд 1.8 хувь, бүсийн дүнд 43.8 хувийг эзэлж улсад эхний 3-т жагсаж байна.

Төсвөө өөрөө бүрдүүлж, өөрийгөө санхүүжүүлдэг аймгийн хувьд нийт гүйцэтгэсэн барилгын ажлын 30.0 орчим хувийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийдэг байна.

Худалдаа нийтийн хоолны бараа гүйлгээний өсөлтөнд барааны дэлгүүр болон хүнсний дэлгүүр, шатахуун борлуулалт, зоогийн газрын орлого ихээхэн хувь эзэлж байна.

Өмнөх онтой харьцуулахад 1000 хүнд ногдох бараа гүйлгээ 63.3 сая.төгрөгөөр өссөн нь худалдааны салбарын өсөлтийг харуулж байна.

Бараа гүйлгээний хэмжээ өссөн нь ажилчидын тоо өссөн ч хөдөлмөрийн бүтээмжийн бууралтанд шууд нөлөөлж байна.

Холбооны салбарын хувьд өнөөгийн монголын цахилгаан холбоо компани нь одоогийн мэдээлэл харилцаа холбооны хөгжлийн суурь болсон байна. Өнөөдөр мэдээлэл харилцаа холбооны салбар хэвийн тогтвортой, технологийн тасралтгүй үйл ажиллагааг хангаж, эдийн засгийн үр өгөөж, техник технологийн оновчтой шийдлийн үндсэн дээр хэрэглэгчээ чанартай үйлчилгээгээр хангаж ажиллаж байна.

Мэдээлэл харилцааны хөгжлийн дүнд үүрэн телефон хэрэглэгчдийн хэрэглээ нэмэгдэж, үүнтэй холбогдон телефон цэгийн тоо 54.5 хувиар буурсан байна. 6-аас дээш насны хүн ойролцоогоор 3 орчим үүрэн телефоны дугаартай байна.

Тээвэр, холбооны салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн аймгийн нийт нэмэгдэл өртгийн 0.3 хувь, улсын тээвэр, холбооны салбарын нийт нэмэгдэл өртгийн 0.02 хувийг бүрдүүлж байгаа нь тус аймгийн эдийн засгийн дэд бүтцийн эдгээр салбар бусад орон нутгаас харьцангуй сайн хөгжсөнийг харуулна.